



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/529

Мөрөн сум

Авто зам, замын байгууламжийг
ашиглалтад оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Бүрэнхаан сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замын нэмэгдүүлэх (Сод Эрдэм ерөнхий боловсролын сургуулийн баруун тал 1,106км хатуу хучилттай авто зам барих) ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот Байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, аймгийн Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Н.Буян-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Авто замын хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Б.Батбаатар (Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад)

Д.Оюун-Эрдэнэ (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга)

Э.Наранчимэг (Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төвийн хяналтын инженер)

Ч.Мөнхтөр (Мөрөн сумын ЗДТГ-ын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

6717011182

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын ЗДТГ-ын дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн, архитектор)

Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын геодезийн мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ч.Төгсбат ("Классик Роуд" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

С.Бямба-Очир ("Хүслэнт бүтээмж" ХХК-ийн захирал)

С.Батбилэг ("Хүслэнт бүтээмж" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Р.Элбэг-Очир (Мөрөн сумын Засаг даргын орлогч)

С.Мөнх-Эрдэнэ (Мөрөн Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Авто зам, замын байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Авто зам, замын байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР